



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2014 оны 02 сарын 25 өдөр

дугаар А-61

Улаанбаатар хот

Агнуурын зарим амьтдыг агнах, түүхий эдийг түүж бэлтгэх,  
экспортлохыг түр хугацаагаар хориглох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн тоо толгойг биологийн аргаар зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор шар үнэг, хярс үнэгийг, тоо толгой нь хорогдож байгаа байдлыг харгалзан тарвагыг тус тус Монгол орны нийт нутгаар, тал хээрийн саарал чонын тоо толгой багасч, хууль бус агнуур буурахгүй байгаа тул саарал чоныг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг 3 жилийн хугацаатай хориглосугай.

2. Монгол орны барагшуны нөөц, тархац хомсдож байгааг харгалзан барагшуныг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, боловсруулж бүтээгдэхүүн болгоогүй түүхий эдийг гадаад улсад экспортлохыг 5 жилийн хугацаатай хориглосугай.

3. Ойн тухай хуулийн 3.1.17-д заасан түймрийн аюултай үед буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10-ныг хүртэл ой, ойт хээрийн бүсэд байгалийн жамаар унасан халиун бугын ясан эврийг түүх, худалдах үйл ажиллагааг хориглосугай.

4. Тарвага, шар үнэг, хярс үнэг, саарал чоно болон бусад агнуурын амьтны тоо толгойг нэмэгдүүлэх, хууль бус агнуурыг бууруулах зорилгоор Амьтны тухай хуулийн 5.4.7, 5.8.3 болон 22-т тус тус заасны дагуу аймаг, сумын нутаг дэвсгэрт агнуурын бүс нутгийг тогтоож, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарахаас өмнө барагшуныг экспортлох зөвшөөрөл аваад улсын хилээр гаргаж амжаагүй, зөвшөөрөл авахаар холбогдох материалыг бүрдүүлж, хүсэлт гаргасан хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдэд 2014 оны 05 дугаар сарын 01-нийг хүртлэх хугацаанд багтааж улсын хилээр экспортлохыг зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, орон нутагт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Т.Эрдэнэчимэг/-т тус тус даалгасугай.

7. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Агнуурын зарим амьтныг агнах, барихыг хориглох, ан амьтны хууль бус агналт, ашиглалтад тавих хяналтыг чангатгах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А-06 дугаар, “Барагшун бэлтгэхийг хориглох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А-117 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 2 дугаар сарын ~~ж~~<sup>ж</sup>ны өдрийн  
~~А-6/~~дугаар тушаалын хавсралт



**Барагшун хилээр гаргах  
зөвшөөрлийн хугацааг сунгах аж ахуйн нэгж**

д/д	ААН-ийн нэрс	Хүсэлт гаргасан огноо	Өмнө олгосон зөвшөөрлийн дугаар	Хилээр гаргах барагшуны тоо хэмжээ /тн/
1	“Төгрөгийн гол” ХХК	2014.02.08	Г.13.15	100
2	“Гүрт Богд” ХХК	2014.02.08	Г.13.10	65,3

**Хууль бусаар бэлтгэсэний улмаас хураагдаж аж ахуйн нэгжийн өмчлөлд байгаа барагшунг хилээр гаргах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж**

д/д	ААН-ийн нэрс	Хүсэлт гаргасан огноо	Хилээр гаргах барагшуны тоо хэмжээ /тн/
1	“Баруун Монгол Интернейшнл” ХХК	2014.02.12	100
2	“Самал” ХХК	2014.02.20	100
3	“Нью гранд френдшип” ХХК	2014.02.20	100
4	“Мянган углзат уул конструкшн” ХХК	2014.02.21	100

--Оо--